

154 Эцсээ хүртэл тэвчицгээе (Матай 24:13)

1. Саад сорилт зовлонг

Сөхрөлгүй хэрхэн тэвчих вэ?

Христ зовон байхдаа

Хүлцэн тэвчиж шагналаа харсан

Бурхныхаа амлалтыг

Баяртай хүлээсэн

(ДАХИЛТ)

Тэсвэр тэвчээртэй байцгаая

Итгэлээ бэхжүүлцгээе

Ехова зоригжуулна

Тиймээс эцсээ хүртэл хамт тэвчицгээе

2. Уйтгар гунигтай

Он жилүүдийг туулан байхдаа

Нулимсаа арчин

Ирээдүйн найдвараа харна

Тэр газрыг, тэр мөчийг

Тэвчээртэйгээр хүлээе

(Дахилт)

3. Бид бууж өгөхгүй

Балмагдан сандарч, айх ёсгүй

Үнэнчээр үйлчилж

Еховагийн өдрийг харцгаая

Тэр өдөр мөд ирнэ

Тэвчээртэйгээр хүлээе

(Дахилт)